

Сургуулийн сүлжээний платформд суурилсан холимог сургалтын судалгаа

Cheng Chunying

*Өвөр Монголын Үндэсний Их Сургууль
Компьютерийн технологийн дээд сургууль*

Хураангуй

Тус өгүүлэл нь "Боловсролын Мэдээллийн 2.0 Үйл Ажиллагааны Төлөвлөгөө", болон "дунд болон урт хугацааны боловсролын шинэчлэл, хөгжлийн төлөвлөгөө (2010-2020)"-ийн дагуу холимог сургалтын практик туршлага ба дээд боловсролын шинэтгэлийн хэрэгцээ шаардлагад тулгуурлан дотоод, гадаадын судалгаа, эрдэм шинжилгээний ажлын үндсэн дээр Өвөр Монголын Үндэсний Их Сургуулийн онлайн сургалтын иж бүрэн платформд суурилсан холимог сургалтын загварыг боловсруулсан. Энэ загварт уламжлалт танхимын сургалтын давуу талыг үр дүнтэй ашиглахын тулд "онлайн" + "офлайн" + "онлайн" горимыг боловсруулж танхимын сургалт болон онлайн сургалтыг хослуулсан байна. Загвар нь сургалтын бүх үйл явцыг гурван үе шатанд хуваадаг: хичээлийн өмнө онлайн-ар суралцах, лабораторийн орчинд явуулах танхимын сургалт, хичээлийн дараах онлайн суралцах зэрэг байдаг. Энэ загварын үр нөлөөг баталгаажуулахын тулд "Өгөгдлийн статистик дүн шинжилгээ хийх программ хангамж" хичээлд практик туршиж дүн шинжилгээ хийсэн. Сургалтын дараа асуулга, ярилцлагаар дамжуулан сурагчдын энэ шинэ сургалтын хэлбэрийг үндсэндээ хүлээн зөвшөөрсөн бөгөөд багш нар холимог сургалтын үр дүнд сэтгэл ханамжтай байгааг харуулсан. Холимог сургалт нь танхимын сургалт, онлайн сургалтын хос давуу талыг нэгтгэсэн бөгөөд харилцан бие биеэ нөхөж, бие биеэ сурталчлах замаар сургалтын үйл явцыг оновчтой болгож, сургууль, бусад сургуулиудын холимог сургалтын талаарх лавлагаа өгөх зорилготой үндсэндээ хүрч чадсан байна.

Түлхүүр үг

Сургуулийн сүлжээний платформ, холимог сургалт, онлайн, хэрэгжилт статистик дүн шинжилгээ хийх программ хангамжийн хичээл

Удиртгал

Мэдээллийн технологийн хурдацтай хөгжилтэй холбоотойгоор мэдээллийн солилцоо нь боловсролын салбарын бүх талыг хамарсан бөгөөд шинэ технологи, шинэ хэвлэл мэдээлэл, шинэ санаа, шинэ үзэл баримтлал энэ сүлжээний орчинд бий болсон байна. Мэдээллийн технологи, дээд боловсролын гүн гүнзгий интеграцийг бий болгох, авьяасын сургалтын загварыг бий болгох, мэдээллийн нөөцийг хөгжүүлэх, боловсролын агуулга, сургалтын арга, сургалтын аргуудыг шинэчлэх ("дунд болон урт хугацааны боловсролын шинэчлэл, хөгжлийн төлөвлөгөө (2010-2020)" зэрэг нь багш болон сурган хүмүүжүүлэгчдийн эрэлхийлэх зорилго болсон.

2000 оноос эхлэн мэдээллийн технологи нь боловсролын мэдээлэлд гүнзгий өөрчлөлт авчирсан бөгөөд уламжлалт сургалтын горим цаг эрэн хөгжилд тохирохгүй болсноос сургалтын шинэ хэлбэр холимог сургалт би болсон байна. Холимог сургалт нь олон жилийн судалгаа, дадлагаар дамжин холимог сургалтын онол, арга, стратеги аажмаар сайжирч, олон сургуулиуд

сургалтын үйл ажиллагаанд холимог сургалтыг хэрэгжүүлж эхэлсэн юм.

Их сургуулиудад холимог сургалтын ажлыг зохион байгуулахад мэдээллийн технологийн дэмжлэгийг ашиглах, сургалтын шинэ загвар гаргах, нарийвчилсан санаануудыг нэгтгэн дадлагажуулах, сургалтын үр нөлөөг задлан шинжлэх, санал зөвлөмжийг нэгтгэх, цаашид авах арга хэмжээний талаар зөвлөмж өгөх явдал бол багш нарын судалгааны үндсэн чиглэл болсон.

Тус судалгаа нь гадаад, дотоодын холимог сургалтын судалгааны практик туршлага дээр тулгуурлан Өвөр Монголын Үндэсний Их сургуулийн холимог сургалтын хэлбэрийг бий болгож, дахин энэ хэлбэрт дүн шинжилгээ хийж, холимог сургалтад холбогдох "Өгөгдлийн статистик дүн шинжилгээ хийх програм хангамж" хичээлд практикийг судалж, судалгааны үр дүнг шинжилж, хураангуйлж эцэст нь тус сургууль болон бусад сургуулийн холимог сургалтын талаар лавлагаа өгөхөд зорьсон.

1 Холимог сургалт

1.1 Холимог сургалт гэж юу бэ?

Холимог сургалт нь «технологид суурилсан сургалттай нүүр тулсан зааварчилгааг хослуулсан сурах орчин юм» гэж үзэж байна. (Graham, 2006)

“Холимог сургалт нь E-Leaming-аас боловсруулсан ойлголт юм. Энэ нь онлайн сурах үйл явцыг илүү уламжлалт аргаар сурах, хөгжүүлэх аргуудыг хослуулсан байдаг. Kaye Throne, 2003

Холимог сургалт нь уламжлалт сургалтын аргын давуу талыг цахим сургалтын давуу талыг хослуулсан гэж үздэг. Холимог сургалт нь үнэндээ сургалтын өөр өөр хэлбэр, сургалтын элементүүдийн холимог юм. Энэ нь уламжлалт сургалт болон сүлжээний сургалтын горимуудын давуу талыг ашиглан сургалтыг дахин зохион байгуулах, сургалтын үр ашгийг сайжруулах зорилготой сургалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд ашигладаг. (He kekang, 2004)

Дээрх холимог сургалтын талаарх тодорхойлолтыг хослуулан, холимог сургалтын «холимог» нь суралцах орчны холимог, суралцах онолын холимог, суралцах нөөцүүдийн холимог байж, уламжлалт танхимын сургалт, онлайн сургалтыг хослуулсан сургалт гэж үзэж болно.

1.2 Сургалтын шинэчлэлийн шаардлага

Боловсролын шинэчлэлийг хурдасгах, хүчирхэг боловсролын улс орныг байгуулах, боловсролын шинэ үеийн мэдээллийг хөгжүүлэх ажлыг дэмжих зорилгоор Боловсролын Яам 2018 оны 4-р сард “Боловсролын Мэдээллийн 2.0 Үйл Ажиллагааны Төлөвлөгөө”-г гаргасан. Энэ төлөвлөгөө нь хүмүүст боловсрол олгох, инноваци, системийг хөгжүүлэх, хөгжлийн тэргүүлэх чиглэлийг нэгтгэх зарчимд суурилж, сургалтын нь бүх багш, сургуулийн бүх оюутныг хамрах бөгөөд дижитал кампусын нь бүх сургуулийг хамрах хэрэгтэй гэж тогтоосон байна. (Боловсролын яам, 2018)

Эдгээр зорилгыг хэрэгжүүлэхийн тулд үндсэн үйл ажиллагааны төлөвлөгөөг системтэйгээр боловсруулсан. Дижитал кампус-ын норматив барилгын үйл ажиллагаа, ухаалаг боловсролын инновацийг хөгжүүлэх үйл ажиллагаа нь «дижитал кампус», «ухаалаг танхим» байгуулахын тулд төлөвлөсөн байна.

Олон дээд сургуулиуд “Боловсролын Мэдээллийн 2.0 Үйл Ажиллагааны Төлөвлөгөө”, болон «дунд болон урт хугацааны боловсролын шинэчлэл, хөгжлийн төлөвлөгөө (2010-2020)»-ийг хэрэгжүүлэхийн тулд боловсролд хандуулах үзэл баримтлал өөрчлөхөөс эхлэн, мэдээлэлд тулгуурласан сургалтын шинэ аргыг нэвтрүүлэх, «дижитал кампус» болон «ухаалаг танхим»

сургалтын орчин бий болгох, мөн шинэлэг авьяастныг хөгжүүлэхийг ирээдүйн боловсрол, сургалтын зорилго болгон байна. Энэ утгаараа мэдээллийн технологи, боловсролын инновацийг нэгтгэсний үр дүнд холимог сургалт нь бодлогын удирдамжийн дагуу хамгийн ур өгөөжтэй хөгжлийн чиглэл болсон байна.

1.3 Холимог сургалтын судалгааны байдал

2013 оноос эхлэн мэдээллийн технологийн хурдацтай хөгжилтөөр **холимог** сургалтын нь ч мэдээллийн технологи, интернетийн сургалтын орчинг танхимын сургалттай хослуулсан сургалтын орчинд шилжсэн байна. Сургалтад **холимог** үзэл баримтлал нь «оюутны чиглэсэн» сургалтын философийг онцолсон бөгөөд холимог сургалтын орчинд суралцагчдын суралцах туршлагад голлон анхаарах болсон.

Холимог сургалт нь уламжлалт сургаалаас ялгаатай юм. Нэг талаас, холимог сургалт нь багшийн удирдлага доор суралцагчдад тулгуурлаж суралцагчдын субьектив санаачилгыг онцолж, багшлах үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт нь суралцагчдын хэрэгцээ, шинж чанарыг бүрэн харгалзан үзэх шаардана. Нөгөөтэйгүүр, холимог сургалт нь мэдлэг бүтээх, асуудлыг шийдвэрлэх, ур чадвар эзэмших чадварыг хөгжүүлэх, сайжруулахад шаардана (Li Cong, 2015).

Сургалтын явцад бид «оюутны чиглэсэн» боловсролын философийг бүрэн хэрэгжүүлж, сургалтын зорилтыг тогтоох, сургалтын агуулгад дүн шинжилгээ хийх, сургалтын стратегийг сонгоход суралцагчдын хөгжлийн шинж байдал, суралцагчдын хоорондын зөрүү, хүлээн зөвшөөрөх түвшинг бүрэн харгалзан үзэх ёстой гэжээ. (Gang Siyi, 2017).

Гадаадын эрдэмтэн Vaughan холимог сургалтыг гурван үе шат хуваасан бөгөөд багш бүр өөр өөр сургалтын стратегиудыг үе шат бүрд хэрэглэхийг зорьсон. Суралцахаасаа өмнө сургалтын үйл ажиллагааг төлөвлөхөд анхаарах тавих, сургалтын явцад оюутнуудтай харилцах харилцаанд анхаарлаа төвлөрүүлэх, суралцсаны дараа сурагчдын хэрэгцээнд тохирсон сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах нь зүйтэй гэжээ. (Feng Xiaotong, Wang Ruixue, et al., 2018)

Дээрх судалгаанаас харахад холимог сургалтын үзэл баримтлалыг боловсруулж, сургалтын үйл ажиллагаанд нэвтрүүлэхэд оновчтой холимог сургалтын загварыг гаргах хэрэгтэй байна. Холимог сургалт нь хичээл, сургалтын материал, сургалтын агуулгыг задлан шинжлэх төдийгүй сургалтын зорилго, сургалтын стратеги, сургалтын үнэлгээ зэргийг багтаасан тодорхой, системтэй төсөл болох юм.

Ийм мөчлөгийн системийн орон зайд хэсгүүд хоорондоо харилцан хамааралтай бөгөөд хоорондоо харилцан үйлчилдэг.

2 Сургуулийн сүлжээний платформд суурилсан холимог сургалтыг зохион байгуулах


2.1 Сургуулийн онлайн сургалтын иж бүрэн платформд суурилсан “өгөгдлийн статистик дүн шинжилгээ хийх програм хангамж” хичээлийг зохион байгуулах загвар

Сургалтын үйл ажиллагаа нь багш болон оюутнууд, оюутнууд болон оюутнууд хооронд тодорхой сургалтын зорилгод хүрэх үйл ажиллагааны горимууд болно. Холимог сургалтын горимд сургалтын үйл ажиллагааны зохион

байгуулах хэрэгжилт нь хамгийн чухал холбоос юм. Энэхүү судалгаанд холимог сургалтыг 3 үе шатанд хуваасан: хичээлээс өмнө онлайн суралцах, сургалтын үндсэн хэсэг болох танхимын сургалт, хичээлийн дараах онлайн суралцах. Уламжлалт танхимын сургалтын давуу талыг ашиглахын тулд бид сургуулийн онлайн сургалтын иж бүрэн платформ суурилсан сургалт болон танхимын сургалт хоёрыг хослуулсан «онлайн» + «офлайн» + «онлайн» сургалт шинэ сургалтын хэлбэрийг ашигласан байна. Сургуулийн сүлжээний платформд суурилсан холимог сургалтын загварыг Зураг 1-т харуулав.

Зураг 1

Сургуулийн сүлжээний платформд суурилсан холимог сургалтын загвар



(1) Холимог сургалтын дах хичээлийн өмнө онлайн сургалт

Сургалтын өмнөх хугацаанд, суралцагчид Өвөр Монголын Үндэстний Их сургуулийн онлайн сургалтын иж бүрэн платформыг ашиглан бие даасан суралцах үйл ажиллагаа явуулна. Багш нар сурагчдын ерөнхий байдал, нөөц бололцоо, сургалтын агуулга зэрэгт тулгуурлан сургуулийн сүлжээний платформд онлайн сургалтын материалыг байршуулах, танхимын сургалтад зориулан онлайн хэлэлцүүлэг зохион байгуулах, сурах бичигтэй холбоотой материалууд, аудио болон бичил видео нөөцүүд, сургалттай холбоотой тестийн асуултуудыг бэлтгэн байршуулан.

(2) Холимог сургалт дах танхимын сургалт

Танхимын сургалт нь холимог сургалтын үндсэн хэсэг болон. Холимог сургалтад танхимын сургалтыг лабораторийн орчинд явуулж багшаас сургалтын зорилтуудын дагуу мэдлэгийн цэгүүдийг тайлбарлаж, суралцагчдад

зориулсан хувь хүний удирдамж, суралцагсдад лавлагаа суралцахад чиглүүлдэг. Багш нар сурагчийн хичээлийн өмнөх бэлтгэл, танин мэдэхүйн чадвараас хамааран хичээлийн агуулга тайлбарлах хэлэлцүүлгийн үйл ажиллагааг зохион байгуулна. Хоёр дахь нь сурагчийн оролцохыг урамшуулан дэмж багуудын хамтын ажиллагааг зохион байгуулж, сурагчдад чиглэсэн удирдамж, зааварчилгаа хангах. Эцэст нь, сурагчдын хичээлийн гүйцэтгэлийн талаарх санал бодлыг үнэлж танхимын сургалтыг байдал нэгтгэн дүгнэнэ. Энэ үе шатанд үйл явцын үнэлгээ нь сургалтын үйл явцын туршид явагддаг.

(3) Хичээлийн дараах онлайн сургалт

Хичээлийн дараах үе шат нь сурагчийн бүх сургалтын явцын үе шатыг шалгахад оршино. Энэ үе шатанд сурагчид онлайн даалгавар гүйцэтгэх, онлайн хэлэлцүүлэг оролцох, онлайн тест гүйцэтгэх шаардлагатай. Багш нар сургуулийн онлайн сургалтын иж бүрэн платформоор дамжуулан илгээсэн даалгавруудыг хянаж,

сурагчдын санал бодлыг нэгтгэн дүгнэж үнэлгээ өгч болно. Энэ үе шатанд сурагчид гар утсан дээр WeChat группээр дамжуулан илүү чөлөөтэй харилцах боломжтой учраас онлайн сургалтын харилцааны нэмэлт болгосон байна.

(4) Холимог сургалтын үнэлгээ


Суралцагчдад үнэлгээ өгөх нь сургалтын бүх үйл явцын туршид хийгддэг бөгөөд энэ нь процессын үнэлгээ ба эцсийн үнэлгээтэй хослуулсан байх ёстой. Холимог сургалтын үйл явц нь гурван үе шатанд хуваагдах учраас холимог сургалтын үнэлгээнд суралцагчдын онлайн болон оффлайн үнэлгээ хийж болдог. Онлайн үнэлгээ нь ихэвчлэн онлайн сургалтын нөхцөл байдал, онлайн тест, сурагчдын хичээлийн хэлэлцүүлгийн гүйцэтгэлийг системээс автоматаар бий болгосон цахим сургалтын файлаар бүртгэдэг. Оффлайн үнэлгээ нь багш нарыг танхимын сургалт, оролцооны байдал болон хичээлийн гүйцэтгэлийг шалгахад зориулагдсан байдаг. Эцсийн үнэлгээ нь ерөнхийдөө ажлын гүйцэтгэл, даалгавар ажлын гүйцэтгэл, эцсийн шалгалтыг багтаадаг.

Энэ холимог сургалтын үнэлгээний хэрэгжилт нь сургалтын явцад суралцагсдын сургалтын динамик болон гүйцэтгэлийг хянах, удирдахад тусалдаг төдийгүй сургалтын стратегиудыг илүү сайн зохицуулж хэрэгжүүлэхэд тусалдаг. Суралцагсдын суралцах сонирхлыг идэвхжүүлэх, онлайн болон оффлайн байдлаар санал бодлоо илэрхийлэх, нэгтгэсэн үр дүнгийн талаар ярилцах замаар багш нар холимог сургалтын үр ашгийг дээшлүүлэх зорилгод хүрэх боломжтой.

Өвөр Монголын Үндэстний Их Сургуулийн онлайн сургалтын иж бүрэн платформ нь оюутны онлайн сургалтыг дэмждэг бөгөөд сурагчид цаг хугацаа, орон зайг хязгааргүй дурын цагт ашиглах боломжтой. Өвөр Монголын Үндэстний Их Сургуулийн одоо “Өгөгдлийн статистик дүн шинжилгээ хийх програм хангамж” хичээлд хэрэгжүүлж байгаа сүлжээний платформ зураг 2-д харуулав. Эдгээр нь холимог сургалтын онлайн сургалтад техникийн хүчтэй дэмжлэг үзүүлдэг.

Зураг 2

Өвөр Монголын Үндэстний Их сургуулийн онлайн сургалтын иж бүрэн платформ




2.2 Сургуулийн онлайн сургалтын иж бүрэн платформ дээр суурилсан “Өгөгдлийн статистик дүн шинжилгээ хийх програм хангамж” хичээлийн холимог сургалтын талаарх судалгаа

1. Суралцагчдын санал асуулгын үр дүнгийн судалгаа

Өвөр Монголын Үндэстний Их Сургуулийн “Өгөгдлийн статистик дүн шинжилгээ хийх програм хангамж” хичээлийг судлах оюутнуудын дунд 2016-2017 оны хичээлийн жилийн хаврын улиралд 199 оюутнууд санал асуулга явуулж дүгнэлт гаргасан. Судалгааг цаасаар авч


боловсруулалтыг Microsoft Excel програмын тусламжтай гүйцэтгэсэн.

(1) Та тус хичээлийн холимог сургалтын хэлбэрд сэтгэл хангалуун байна уу?




Санал асуулгын үр дүнгээс харахад 146 суралцагчдын холимог сургалтын хандлагад сэтгэл хангалуун байж, 44 суралцагчид ерөнхийдөө сэтгэл хангалуун байдаг гэж үздэг бөгөөд 9 оюутан тус холимог сургалтад сэтгэл ханамжгүй байдаг. Ерөнхийдөө ихэнх суралцагчид тус холимог сургалтыг хэлбэрийг дэмжих байдал харагдан.

(2) Тус хичээлийн холимог сургалтын талаар та ямар ололтой вэ?



Санал асуулгын дүнгээс харахад суралцагчдын 82.15% нь “сургалтын олон арга барилыг мэдэрч, янз бүрийн сургалцах аргыг эзэмшсэн” гэснийг сонгож, суралцагчдын 69.56% нь “бие даан сургалцах чадварыг сайжруулсан” гэснийг сонгосон байна. Суралцагчдын 13.21%, 24.34% нь “Мэргэжлийн мэдлэгийг сурч, практик чадвараа дээшлүүлсэн” ба “Сүлжээний үр чадвар ба мэдээлэл авах чадварыг дээшлүүлсэн” гэдэг сонгосон, 4.23% нь бусад сонгосон байна. Энэ нь холимог сургалтаар дамжуулан суралцагсдад сургалтын шинэ хэлбэр, шинэ аргуудын хамгийн сэтгэл ханамжтай байдаг бөгөөд тэдний сурах чадвар, сурах ухамсрыг дээшлүүлсэн гэдэг харуулж байна.


(3) Сургуулийн онлайн сургалтын иж бүрэн платформд танд аль үйлчилгээг өгөхийг хүсэж байх вэ?



Санал асуулгын дүнгээс үзэхэд, суралцагчдын 79.36% нь “Веб дээр хичээлийн


агуулга холбоотой видеоны эх сурвалжууд ба баримтууд” гэснийг сонгож, суралцагчдын 56.32% нь “Илүү олон сурах арга барил ба арга зүйг олгох” сонгосон байна. Суралцагчдын 23.23%, 13.15% нь “Багш өөрөө бичсэн бичил видео аудио нөөц” ба “Хичээлд зориулсан хичээлийн болон сургалтын материалууд” гэдгийг сонгосон, 7.36% нь бусдыг сонгосон байна. Бусад сонгосон суралцагч гол төлөв багшийг асуудалд дүн шинжилгээ хийхэд зориулсан санаа, арга барилыг авахыг хүсдэг. Дээрх судалгааны үр дүнгээс харахад ихэнх сурагчдын сурах арга барил хангалтгүй байх, багшийн хичээлийн материалыг платформ дээр байршуулах хүсэж байна.

(4) Та веб платформ дээрх суралцах даалгаврыг илгээх хэлбэрт сонирхолтой байна уу?



Судалгааны үр дүнгээс харахад, суралцагчдын 83.21% нь энэ холимог сургалтын аргыг хэрэглэхэд хялбар, хурдан байдаг, суралцагчдын 16.79% нь уламжлалт сургалтын арга барилд дасаж, платформыг мэргэжлийн бусаар ашиглахтай холбоотой асуудлууд ихэвчлэн байдаг.

(5) Та сурах үйлийн үнэлгээний бодит байдалд сэтгэл хангалуун байна уу??



Судалгааны үр дүнгээс харахад, суралцагчдын 48.61% нь холимог сургалтын үнэлгээ ихэнх тохиолдолд бүхэлдээ бодитой байдаг гэсэн байна. Энэ нь үнэлгээний үнэн бодитой байдалд суралцагчид итгэдгийг харуулж байна.

Судалгааны нийт дүн шинжилгээгээ харахад, ихэнх суралцагчд холимог сургалтад сэтгэл ханамжтай байдаг бөгөөд сурагчдын идэвх санаачилга, оролцоо нь уламжлалт сургалтын аргаас сайжирсан. Гэхдээ холимог сургалтын үнэлгээ үнэн бодитой байх үндсэн шаардлагаа бүрэн хангахгүй байх байдал оршиж байна.

2. Багш нарын ярилцлагын үр дүнгийн дүн шинжилгээ

Энэхүү судалгаанд холимог сургалтын хэрэгжилтийн үр дүнг шинжлэн асуулгын судалгааны явуулсны бөгөөд хичээлд хамрагдсан бусад багш нар ярилцлага авч, холимог сургалтын хэрэгжилтийн үр нөлөөг цаашид гүнзгийрүүлэн ойлгох, ирээдүйд холимог сургалтын ажлын талаар илүү их санал бодол, санал зөвлөмж өгөхийг хүсэж байна.

Энэ судалгаанд хамрагдсан багш нь 20 гаруй жилийн туршлагатай ахлах багш юм. Олон ярилцлага хийх үеэр багш нь холимог сургалтын сурах арга барил, сургалтын үр нөлөөг гүнзгий, бүрэн ойлгосон байдаг олж мэдсэн. Багш нартай ярилцлагын асуулт ба үр дүнг авч үзлээ. Үүнд:

(1) Холимог сургалтын үр нөлөөг та юу гэж үзэж байна вэ?

Багш: Холимог сургалтын үр дүнд сэтгэл хангалуун байна. Холимог сургалтын дараа сурагчдын сургалтын үр нөлөөг дээшлүүлж, сурагчдын өдөр тутмын ажлын чанар, эцсийн дүн, чадварыг дээшлүүлсэн, ялангуяа сурагчдын бие даан суралцах чадвар, багийн хамтын ажиллагааны чадвар, харилцаа холбоо, хэлэлцүүлгийн ур чадвар сайжирч байна.

(2) Холимог сургалт явуулах нь сурагчдад ямар нөлөө үзүүлдэг гэж та үзэж байна вэ?

Багш: Юуны өмнө, холимог сургалтын танхимын сургалт нь суралцагчдад сургалтын хөтөлбөрийн системийн мэдлэгийг дээшлүүлэхэд тусалдаг бөгөөд энэ нь багш нарын хяналт, удирдамж, удирдан чиглүүлэх, сэтгэл хөдлөлийн харилцаа холбоог дэмждэг. Хоёрдугаарт, энэ суралцах хэлбэрээр нээлттэй, чөлөөтэй суралцах хэлбэр байж, онлайн сургалтын нь оюутнуудад илүү өргөн хүрээг хамарсан сургалтын зай, сургалтын илүү их нөөцийг олгож, суралцагчдад бие даан суралцах, бүлэглэх хамтын ажиллагааг үр дүнтэй явуулах боломжтой. Холимог сургалт нь танхимын сургалт, онлайн сургалттай харьцуулахад хоёр сургалтын давуу талыг бүрэн дүүрэн ашиглан, суралцахдаа сэтгэл хангалуун байж, сэтгэн бодох чадварыг дээшлүүлж, харилцааны хувьд сайн байх сайн сурч судлах чадварыг эзэмших боломжийг олгодог.

(3) Та холимог сургалтад ямар санал, зөвлөгөөг өгөх вэ?

Багш: Юуны өмнө, холимог сургалт нь ихээхэн давуу талтай боловч багшийн мэдлэг, чадварын түвшин, цаг хугацаа, эрч хүчийг шаарддаг. Хоёрдугаарт, онлайн сургалтын цогц платформыг байгуулж, онлайн харилцааны хэлэлцүүлэг, онлайн асуулт хариулт, интернетийн үнэлгээ, платформын бусад функцүүд би болгон холимог хөгжлийг дэмжиж практик стратеги болон арга барилыг боловсруулах зайлшгүй шаардлагатай.

Багш нарын ярилцлагын үр дүнгээс бид энэ удаагийн холимог сургалтын дадлагыг үндсэндээ хүлээгдэж буй үр дүнд хүрсэн гэдгийг тодрууллаа. Сурагчдын нийтлэг чанар нь урьд өмнөхүүдтэй харьцуулахад сайжирсан ба ихэнх сурагчид шинэ сургалтын хэлбэрд дасан зохицох чадавхтай бөгөөд багш нарыг тогтоосон цаг хугацаанд нь хийж гүйцэтгэх ажлуудыг хийсэн байна.

Дүгнэлт

Өдгөө холимог сургалт нь мэдээллийн технологийн хөгжлийн чиг хандлагатай уялдан улам хүчирхэг сургалтын хэлбэр болж байна. Судалгаанаас дараах дүгнэлтүүдийг хийж байна. Үүнд:

(1) Энэхүү холимог сургалтын практик үр дүнгээс харахад суралцагчид энэ шинэ төрлийн сургалтын талаар үндсэндээ санал нийлж, багш нар холимог сургалтын нөлөөний сэтгэл ханамжтай байна.

(2) Холимог сургалт нь сургалтын аргууд, сургалтын агуулга, харилцан үйлчлэл, сургалтын стратеги гэх мэт таалд бүр өөрийн онцлогтой байж уламжлалт хичээлийн сургалтаас илүү уян хатан байдаг.

(3) Холимог сургалтын үнэлгээ үнэн бодитой байх үндсэн шаардлагаа бүрэн хангахгүй байгааг байдал оршиж байна.

(4) Холимог сургалт нь танхимын сургалт, онлайн сургалтын хос давуу талыг нэгтгэсэн бөгөөд харилцан бие биеэ нөхөж, бие биеэ сурталчлах замаар сургалтын үйл явцыг оновчтой болгож, сургалтын зорилтоо биелүүлдэг.

(5) Их сургуулийн суралцагчид субьектив сэтгэлгээ, логик сэтгэлгээний чадвар, судалгаа шинжилгээний талаарх субьектив чадвартай тул холимог сургалт шинэ арга замыг илүү хүлээн зөвшөөрөх хандлагатай байдаг. Сурагчид холимог сургалтын давуу талыг чөлөөтэй ашиглана, өөрийн суралцах, бие даасан лавлагаа суралцах үйл ажиллагаа явуулах, бүлгийн хамтын ажиллагааны сургалт явуулах нь илүү сайн мэдлэг бүтээх боломжтой.

(6) Холимог сургалтын орчинд сургалтын хөтөлбөрийн бүтэц, сургалтын үйл ажиллагааны зохистой зохион байгуулалт, багшийн удирдлага, удирдамжтай хослуулан, багшийн хяналт олон талын туслалцаатайгаар сургалтын үр дүнг дээшлүүлэх боломжтой байна.

Ном зүй

国家中长期教育改革和发展规划纲要工作小组办公室.国家中长期教育改革和发展规划纲要(2010-2020年)[EB/OL]. http://www.moe.edu.cn/srcsite/A01/s7048/201007/t20100729_171904.html

Html

中华人民共和国教育部.(2018)教育信息化2.0行动计划.[EB/OL].http://www.moe.gov.cn/srcsite/A16/s3342/201804/t20180425_334188.html

Graham, C. R. (2006) Blended learning systems: definition, current trends, and future directions. edited by C. J. Bonk and C. R. Graham In Handbook of Blended Learning: Global Perspectives, Local Design, San Francisco, CA: Pfeiffer Publishing. x.3-21.

Kayefhorrlle.(2003). *Blended learning:how to integrate online&traditlonal leaming*. London: KoganPageLilnited.

何克抗.(2007)从 *Blending Learning* 看教育技术理论的新发展.电化教育研究.(7).

李聪.(2015) 基于 *Mooc* 的思想道德修养与法律基础课混合式教学研究.□□师范大学.

管思怡.(2017).基于慕课的混合式教学研究---以海南高校慕课教学为例.□□师范大学.

冯晓英,王瑞雪,吴怡君.(2018)国内外混合式教学研究现状述评---基于混合式教学的分析框架.远程教育杂志.(3) x.12-24.

Joi L.Moore, Camille Divkson-Deane, Krista Galyen(2011).*E-Learning,Online learning, and Distance learning environments: Are they the same?*. The internet and Higher Education.14(2) x.129-135.

Cooney M, HGupton P,Laughlin M(2000).*Blurring the lines of play and work to create blended classroom learning experiences*.Early Childhood Education Journal. (3) x.165-171.

Allen I E, Seaman J, Garrett R (2007). *Blending in: the extent and promise of blended education in the United States*.*Proceedings of The Sloan Consortium*. [ht-tp://sloanconsortium.org/sites/default/files/Blending_In](http://sloanconsortium.org/sites/default/files/Blending_In).

张洁,王以宁. (2010)基于境脉感知的移动混合式学习系统设计.现代远程教育.(5) x.37 - 40.

蒋玲,黄磊,张丹清(2012).基于 *Windows Live* 群的

混合式学习课程平台应用研究.□□电化教育,

(10):136-140.

王胜清,冯雪松. (2017)基于慕课的混合式教学的设计与实践.现代教育技术.(11) x.71-77.

杜世纯,傅泽田.(2016)基 *MOOC* 的混合式学习及其实证研究.□□电化教育.(12) x.129-133.

Намсрайдоржийн Мөнхцэцэг (2013).*Цахим сургалтын програм хангамжийн дэд бүтцийн бүрэлдэхүүн хэсгүүдийн хөгжүүлэлт,туришилтын асуудалд*.монгол улсын их сургууль Улаанбаатар хот.

Research on mixed teaching based on campus platform

*Cheng Chunying,
Inner Mongolia University for Nationalities*

Abstract

According to the "Education Informatization 2.0 Action Plan" and the "National Medium- and Long-Term Education Reform and Development Plan (2010-2020)", this paper starts from the needs of higher education reform, based on the practical experience of mixed learning research in China and abroad, a mixed teaching model based on the network teaching platform of Inner Mongolia University for Nationalities was designed. In order to effectively utilize the advantages of the traditional classroom model, we designed the "online"+"offline"+"online" mode in parallel with the classroom teaching mode and the network learning mode. This model divides the whole teaching process into three stages: online learning before class, laboratory teaching in class, online learning and WeChat group communication after class. In order to verify the validity of the teaching model, the model is applied to the statistical analysis software course. After the course, the questionnaires and interviews were used to understand that the students basically accepted this new type of teaching method, and the teachers were more satisfied with the mixed teaching effect. The mixed teaching mode integrates the dual advantages of classroom learning and online learning. Through the mutual complementation and mutual promotion of the two, the teaching process is optimized, and the purpose of providing reference and reference for the mixed teaching of the school and other schools is basically achieved.

Keywords

School network platform, Mixed teaching, Online, Implementation, Data statistical analysis software course
